

Монгол улсын Үнэт цаасны хорооны  
2003 оны 2 дугаар сарын 21-ний өдрийн  
14 дүгээр тогтоолын 5 дугаар хавсралт

**ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ, ЗАХ ЗЭЭЛД ОРОЛЦОГЧ МЭРГЭЖЛИЙН  
БАЙГУУЛЛАГЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД НЭМЭЛТ,  
ТОДРУУЛГА БЭЛТГЭХ ЖУРАМ**

**НЭГ. Нийтлэг үндэслэл**

1.1. Үнэт цаасаа Хороо болон Хөрөнгийн биржид бүртгүүлж, нийтэд санал болгон арилжаалж буй болон үнэт цаасны зах зээл дээр мэргэжлийн үйл ажиллагаа явуулж байгаа компанийн санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүнг харуулах санхүүгийн тайлан тэнцлийн үзүүлэлтийг дэлгэрэнгүй болгох зорилгоор нэмэлт тодотгол тайлбартай гаргуулах, хөрөнгө оруулагчид болон харилцагчдад бодитой, үнэн зөв мэдээллийг хүргэхтэй холбогдож “Үнэт цаасны зах зээлийн тухай” хуулийн 34.1.10 дугаар заалтыг хэрэгжүүлэхэд энэхүү журмыг мөрдөнө.

**ХОЁР. Санхүүгийн тайлангийн  
тодруулга бэлтгэх журам**

2.1. Санхүү, эдийн засгийн сайдын 2000 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн 64 тоот тушаалаар баталсан “Санхүүгийн тайлангийн тодруулга бэлтгэх үлгэрчилсэн заавар”-ыг баримтлан үнэт цаас гаргагч болон үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагууд жилийн тайландаа хавсаргах тодруулгыг бэлдэнэ.

**ГУРАВ. Санхүүгийн тайланд  
хийх нэмэлт тодруулга**

3.1. Үнэт цаас гаргагч компаниуд 2.1-д заасан зааврын доорхи хэсгүүдэд компанийн хувьцаа эзэмшигчдэд шаардлагатай нэмэлт тодруулга, тайлбарыг оруулна.

3.1.1. Зааврын □Аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа ба зохион байгуулалт□ гэсэн хэсэгт:

а.Төлөөлөн удирдах зөвлөл болон хяналтын зөвлөлийн гишүүдийн тоо, тэдгээр тус бүрийн эзэмшиж буй хувьцааны тоо, хувь болон тэдгээртэй нэгдмэл сонирхолтой этгээдийн нэр;

б. Тайлангийн хугацаанд их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийсэн бол энэ тухай мэдээлэл, эдгээр хэлцлийг баталсан эрх бүхий удирдах байгууллагын нэр, шийдвэрийн дугаар, огноо;

в. Компанийн хувьцааны багцыг нэгдмэл сонирхолтойгоор эзэмшиж буй этгээдүүд бий эсэх, байгаа бол тэдгээрийн нэр, эзэмшиж буй хувьцааны тоо, хувь.

3.1.2. □Бусад нэмэлт тодруулга□ гэсэн хэсэгт 4-14 дэх хэсгүүд болгон дараахь асуудлуудыг нэмж тодруулах.

4. Тайлангийн хугацаанд нэмж болон шинээр гаргасан үнэт цаасны тоо, нэрлэсэн үнэ, хүү, эргэж төлөгдөх хугацаа, барьцаалсан хөрөнгийн жагсаалт;

5. Тайлангийн хугацаанд эргүүлэн худалдан авсан халаасны хувьцааны тоо, зах зээлийн үнэ, эргүүлж худалдахаар зөвшөөрсөн эрх бүхий удирдах байгууллагын шийдвэрийн огноо;

6. Халаасны хувьцаа худалдан авах болсон шаардлага, үндэслэл;

7. Үнэт цаасаар хийсэн урт ба богино хугацаатай хөрөнгө оруулалтын үлдэгдлийн дэлгэрэнгүй жагсаалт;

8. Компани нь Компанийн тухай хуулийн 6.3, 6.4 дэх заалтын дагуу толгой, охин, хараат компанитай бол тэдгээрийн хоорондын өр, авлагын тооцоо, тэдгээрт оруулсан хөрөнгийн талаархи тодруулга;

9. *Компани нэгдсэн, нийлсэн, хуваагдсан, тусгаарлагдсан тохиолдолд төсөлд тусгасан үнэт цаасыг бусад хөрөнгөнд болон шинээр үүссэн компанийн үнэт цаасанд хөрвүүлсэн байдлын талаар мэдээлэл;*

10. *Компанийн өрийг хувьцаагаар сольсон бол өрийг хувьцаагаар сольсон нөхцөлийн талаархи дэлгэрэнгүй мэдээлэл;*

11. *Компанийн тухай хуулийн 34.2-т заасны дагуу гаргасан хувьцааны тоог компанийн балансад төрөл тус бүрээр нь тусгаж, зарласан хувьцаа, түүнээс гаргасан хувьцааны төрөл, хэлбэр, үнийн талаар мэдээлэл;*

12. *Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ хийлгэсэн бол үнэлгээ хийсэн компанийн нэр, хийлгэсэн үнэлгээний арга, үнэлгээний зөрүүг тайланд хэрхэн тусгасан талаар нэмэлт мэдээлэл;*

13. *Ногдол ашиг тараахаар шийдвэрлэсэн бол түүний хэмжээ, төлбөр хийх арга/мөнгөөр, эд хөрөнгөөр, хувьцаагаар/ тараах арга хэлбэр.*

3.2. Үнэт цаасны мэргэжлийн байгууллагууд санхүүгийн тайландаа дээрх зааварт зааснаас гадна дараахь үзүүлэлтийг нэмж тусгана.

3.2.1. Компани болон түүний эрх бүхий албан тушаалтан, тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээдийн эзэмшиж буй үнэт цаасны нэр төрөл, тоо хэмжээ.

3.2.2. Тайлангийн хугацаанд их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийсэн бол энэ тухай мэдээлэл, эдгээр хэлцлийг баталсан эрх бүхий удирдах байгууллагын шийдвэрийн огноо, дугаар.

3.2.3. Үнэт цаасаар хийсэн урт, богино хугацааны хөрөнгө оруулалтын төрөл, нэр, тоо, үнийн дүн.

**ДӨРӨВ. Санхүүгийн тайлангийн нэмэлт,  
тодруулгыг хүлээн авах, боловсруулах,  
мэдээлэх**

*4.1. Хагас жилийн болон аудитын байгууллагаар баталгаажуулсан жилийн эцсийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасан хугацаанд гаргаж энэхүү журамд заасан нэмэлт тайлбар, тодруулгын хамт Хороонд ирүүлж байна.*

4.2. Хариуцсан мэргэжилтэн санхүүгийн тайланг нэмэлт тайлбар, тодруулгын хамт хянаж хүлээн аваад хуудас тус бүрд □бүртгэв□ тэмдгийг дарж компанийн хавтаст хадгална.

4.3. Санхүүгийн тайлан болон нэмэлт, тодруулгад дурдсан мэдээллийг аудитын байгууллагаар хянуулж баталгаажуулсан байна.

4.4. Компанийн жилийн эцсийн тайлангийн үзүүлэлтийг үйл ажиллагааны салбар чиглэлээр нь нэгтгэж, санхүүгийн үйл ажиллагааны үр дүнгийн үзүүлэлтүүдэд шинжилгээ хийж дүгнэлт гаргана.

4.5. Холбогдох хэлтсүүд компанийн жилийн эцсийн тайлан, тайлбар тодруулгад тулгуурлан шинжилгээ дүгнэлт хийж нэгтгэн эхний хагас жилд багтаан Хорооны хуралдаанд оруулна. Шаардлагатай гэж үзвэл энэ талаар нийтэд дэлгэрэнгүй мэдээлнэ

4.6. Салбараар гаргасан дээрх санхүүгийн шинжилгээ, дүгнэлтийг тусгай хавтас нээж хадгална.

4.7. Тухайн компанид хөрөнгө оруулах сонирхолтой этгээд, үнэт цаас эзэмшигчдэд компанийн хувийн хэрэг болон санхүүгийн тайлан, түүнд хавсаргасан нэмэлт мэдээллийг танилцуулж болно. Харин хуулбарлан авах бол түүнтэй холбогдсон зардлыг сонирхогч этгээд хариуцна.

4.8. Жилийн тайлангийн хураангуйг Хорооноос баталсан журмын дагуу өдөр тутмын аль нэг хэвлэлд нийтэлж, хөрөнгө оруулагчдад хүргэх асуудлыг үнэт цаас гаргагч хариуцаж хэрэгжүүлнэ.

*ТАВ. Хариуцлага тооцох*

5.1. Энэ журмыг зөрчиж, хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлээгүй этгээдэд Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23.1.3, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 38.1.1-д заасан захиргааны шийтгэл ногдуулахаас гадна улсын байцаагч нар хуульд заасны дагуу холбогдох арга хэмжээ авна.